

№	Нэр	Эх сурвалж	Санал, хүсэлт, асуулт	Хариулт
1	Onon Lkhajaa	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд мессежээр	Баянхонгор аймгийн ОНХС-н мэдээлэл өгч туслаач. Баярлалаа	Сайн байна уу? Та аймгийнхаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, санхүү төрийн сангийн хэлтэс эсвэл "Тогтвортой амьжиргаа-3" төслийн Баянхонгор аймаг дахь ажилтан Болдбаатар 99442858 холбогдож мэдээлэл аваарай. Мөн ОНХС-ийн http://tusuv-oronnutag.mof.gov.mn МЭДЭЭЛЛИЙН САН цэсэнд нэвтрэн Баянхоногор аймгийн хэсгийг үзэж танилцана уу! Холбогдсонд баярлалаа.
2	Б. Тогоо	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд мессежээр	Сайн байна уу. Тогтвортой амьжиргаа 3 төсөл хэрэгжиж байгаад баяртай байна. Суманд уг төслийн зохицуулагчийн ажлын байр байдаг болов уу.	Сайн байна уу? "Тогтвортой амьжиргаа-3" төсөл одоогоор зөвхөн 21 аймагт тус бүр 1 орон нутгийн ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Өөрөө хэлбэл суманд ажилтан байдаггүй юм. Баярлалаа.
3	Батцэцэг Тогооч	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд мессежээр	орон нутгийн хөгжлийн сангийн журам нь 288 тушаалаар ОНХС-ийн үйл ажиллагааны журам болон шинэчлэгдээд хуучин ОНХС-ийн журмын 4,4 заалтаар байгуулагдаж байсан ИТХ-ын дэргэдэх "Хяналтын зөвлөл" хүчингүй болсон гэсэн үг үү	Сайн байна уу? ОНХС-ийн зохицуулалт хийж байсан хуучин журам, заалт нь хүчингүй болсон ч гэлээ бусад хууль, журмын зохицуулалтаараа ИТХ өөрсдийн эрх, үүргийн дагуу "Хяналтын хороо" нь хүчин төгөлдөр хэвээр үйл ажиллагаагаа явуулна.
4	Т. Бат-Эрдэнэ	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд мессежээр	ОНХСангаас батлагдсан төслүүдийнхээ баримт нотолгоо гэх зураг зүйлсийг тухайн сайт дээрээ тус орон нутгийн газарын хийгдсэн ажилыг баримттай нь тавьж болох уу	Сайн байна уу? Таны саналыг хүлээж авлаа. Та сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтуудыг ОНХС-ийн цахим хуудас www.tusuv-oronnutag.mof.gov.mn -ы МЭДЭЭЛЛИЙН САН цэснээс үзнэ үү.
5	Ганхуяг Өлзийсайхан	ОНХС-ийн фэйсбүүк	ОНХС болон ОНХНС юугаараа ялгаатай вэ	Сайн байна уу? Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (ОНХНС)-ийн эх үүсвэрийг НӨАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хайгуул хийх, олборлолт

		хуудсанд мессежээр		хийх тусгай зөвшөөрлийн орлого зэрэг төсвийн орлогын тодорхой хувиар тооцож бүрдүүлдэг. Харин "Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ний өдрийн 230 дугаар тогтоолоор батлагдсан ОНХС болон ОНХС -аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал"-ын дагуу ОНХС-ийн хөрөнгийг аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-нд жил бүр хуваарилдаг.
6	Odonchimeg Myagmarsuren	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд мессежээр	Сайн байна уу? Төв аймгийн Мөнгөнморьт сумаас холбогдож байна. Сумын төсвийн ил тод байдлын хэрэглүүрийн загвараа явуулах боломж байна уу.	Сайн байна уу? Төв аймаг дахь "Тогтвортой амьжиргаа-3" төслийн ажилтан Буманбуянтай холбогдож авна уу, 91917397
7	Боржигон Хиад Батбаяр Гансүх	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд мессежээр	Сайн уу? Булган аймаг Тэшиг сум Жаргалант багийн Засаг дарга Б.Гансүх гэдэг хүн байна. Та бүхнээс мэдээлэл авч байна шүү. Ийм их мэдээлэлтэй пайсбүүк хаяг байна гэж санасангүй. Амжилт Зөвлөн тусалж байгаарай.	Баярлалаа Гансүх! Та Булган аймгийнхаа группэд орсон уу? https://www.facebook.com/groups/248372992707716/ ОНХС-ийн нэгдсэн бүлэгт мөн нэгдээрэй. https://www.facebook.com/groups/166895554126807/
8	Batnaa Batnaa	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд мессежээр	Орон нутгийн хөгжлийн сангийн бүлгийн ярилцлагыг яаж зохион байгуулах бэ	Сайн байна уу? "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 5.4-т бүлгийн хэлбэрээр санал авах тохиолдолд 50-аас доошгүй /сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны хувьд 30-аас доошгүй/ иргэний бүрэлдэхүүнтэй бүлгийн ярилцлага, хэлэлцүүлгийг бүлэг тус бүр 2-оос доошгүй удаа зохион байгуулах ба хэлэлцүүлгийн үеэр иргэдээс авсан саналыг энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусган хэлэлцүүлэгт оролцсон иргэдийн гарын үсгээр баталгаажуулна гэж заасан. http://tusuv-oronnutag.mof.gov.mn/ та энэ вэбсайтын хууль, эрх зүйн хэсгээр ОНХС-ийн үйл ажиллагааны журмыг бүрэн эхээр нь харж болно.
9	Батмөнхийн Төрболд	ОНХС-ийн фэйсбүүк	Ажлын байраа нээлттэй зарладаг уу	Сайн байна уу? ОНХС-ийн цахим хуудсанд болон фэйж хуудсанд зарладаг

		хуудсанд мессежээр		
1 0	Гарьд Болортунгалаг	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд мессежээр	Yaj oroltsoh ve?	Сайн байна уу? Та баг, хорооныхоо Засаг дарга, хэсгийн ахлагчид ОНХС-ийн санал өгье гээд хандаарай! Мөн санал хураах Иргэдийн нийтийн хуралдаа суумаар байна. Хэзээ болох вэ? ОНХС-ийн талаарх мэдээлэл авмаар байна, тайлбарлаж өгөөч гээд хандаарай! Ер нь иргэд 5-р сард хийгдэх ИНХ-аас өмнө саналын хуудсаар саналаа өгөөд 5-р сард хийгдэх ИНХ дээрээ очиж саналаа баталгаажуулах хэрэгтэй байдаг. Та www.tusuv-oronnutag.mof.gov.mn сайтаар орж мөн мэдээлэл авч байгаарай. https://www.facebook.com/LDFMongolia/videos/247258385952090/?t=0 энэ видеог үзнэ үү.
1 1	Enkhmaa Enkhbat	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд мессежээр	ОНХСАНгийн танилцуулга авъя.	http://tusuv-oronnutag.mof.gov.mn/ Та энэ хуудаснаас мэдээлэл аваарай!
1 2	Erik Bat	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Өөрийн ажиллаж амьдарч байгаа орон нутагт хэрэгжиж буй "Тогтвортой амьжиргаа" төслүүдийн хэрэгжилтэд иргэд олон нийтийн байгууллагын зүгээс хэрхэн хяналт тавих вэ.	Сайн байна уу? "Тогтвортой амьжиргаа-3" төсөл нь 21 аймаг тус бүрд төслийн ажилтан. Төсөлтэй холбоотой саналаа төсөл хэрэгжүүлэх нэгжид хандан гаргах боломжтой /info@slp3.mn/. Харин #ОронНутгийнХөгжлийнСангийн талаарх мэдээлэл болон саналын хуудсаа баг, хорооныхоо Засаг даргадаа хандан авах эрхтэй. Хэрэв таны саналыг хүлээн авахгүй болон мэдээлэл өгөхгүй байгаа тохиолдолд info@slp3.mn цахим шуудангаар өргөдөл, гомдлоо илгээнэ үү. Мөн ОНХС болон манай төслийн талаарх мэдээллийг www.tusuv-oronnutag.mof.gov.mn цахим хуудаснаас авч байна уу. Баярлалаа.
1 3	Соёлмаа Лувсандорж	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Тогтвортой амьжиргаа -2 төсөл 330 суманд ажилтантай ажиллаж байсан. Үнэхээр малчид сумын нийгмийн асуудлыг шийдэж чадаж байсан шүү. Харин одоо бол	Сайн байна уу? "Тогтвортой амьжиргаа-3" төсөл юу хийж байгаа талаар энэхүү линкээр дарж тайлан нэвтрүүлгээс үзнэ үү! Баярлалаа. https://www.facebook.com/LDFMongolia/videos/375358400086040/?xts__[0]=68.ARCuz590zxrhCGXSo41bT73xllw7GkQxGqI9WqercJOFhaPrc7GR17Hbv5-H82Dej3TvWEF6gwa8IP2ZV1CPrWylBMRT5aFpbjHdkDe10Y_j0hdK3dlolGndu8CwQaie-

			хаана юу хийгээд байгааг хэн ч мэдэхгүй байна	mpRTXtdW8dds1xP3wsQtMzUuUsThbg8cjHJtiR3OjKx8J3Wz2R2HODHSGJL87c9LxfhUjW2C_JuPjQlzyXmN75i9cfdgtonTsQ3W5iqEU1d9S_hjZjAk7evX8xTsWrlQTrzOlq-eHkO5fEkc3_tcRE_n4MDYMzbXlJOfaNzaGvm7b8RNePCPA9cAWeTbej4Gp_gZxGNOISrLUuJKirLCl9cUdplBiNbO9gSOMsA&_tn_=-R
1 4	Khukhuusuren Bodoosh	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Хаана саналаа бичих юм бэ	Та хорооны Засаг даргаасаа саналын хуудас авч бөглөөрэй. Үүний дараа 5-р сард багтаан зохион байгуулдаг ИНХ-ынхаа товыг асууж байгаад танай хорооноос гарсан бүх саналыг эрэмбэлэх хуралд заавал оролцож санал тус бүрээр хэлэлцэн баталаарай. Иргэдэд мэдээлэл түгээх, иргэдээс санал авах үүрэг нь баг, хорооны Засаг дарга, сумын ОНХС-ийн ажлын хэсэг гэх мэт тус тусын албан хаагчдын үүрэг байдаг. Баг бүр дээр, хороо бүр дээр гаргасан саналууд өөр бөгөөд энэ тухай мэдээллийг баг, хорооны Засаг даргад хандан авах боломжтой. Өнгөрсөн онд батлагдаад энэ онд хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтуудыг дүүрэг, сумынхаа батлагдсан төсвөөс харах боломжтой юм шүү. Улсын хэмжээнд 1500 гаруй багаас олон санал гарч тэр нь сум, дүүрэгт очиж эрэмбэлэгдээд сум, дүүргийнхээ ИТХ-аар батлагддаг учир шат, шатны удирдлагуудаасаа мэдээлэл авах, шаардах эрхтэй юм. 5-р сард болдог баг, хорооны ИНХ-ынхаа товыг асууж байгаад хуралдаа заавал оролцож, өөрийн баг, хороонд хийлгэх хүсэлтэй байгаа хөрөнгө оруулалтуудад саналаа гаргаарай та.
1 5	Undral Gombodorj	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Ямар-ямар төслүүд, яг ямар хороо, багаас ирсэн, тэгээд саналын тоог баримтаар тавьж танилцуулна уу. Эс тэгвээс "дэмжигдсэн байна" гэдэг маш хангалтгүй, лозунг болоод байна.	Сайн байна уу? Та аймаг, сумдын ОНХС-ийн мэдээллийг http://tusuv-oronnutag.mof.gov.mn/ хуудасны МЭДЭЭЛЛИЙН САН хэсгээс үзээрэй. Эсвэл баг, хороо, сум, дүүргийнхээ ЗДТГ-аас тодруулах боломжтой юм.
1 6	Bayartsetseg Terbish	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Хэрэгжүүлсэн ажлаа бусдад түгээн, мэдээлж, хуваалцаж байгаад баярлалаа. Өмнө нь ийнхүү нийгмийн сүлжээгээр тайлагнаж байгааг тэр бүр санахгүй байна.	Баярлалаа. Та үргэлж хамт байж мэдээлэл авч байгаарай!

1 7	Battsetseg Baagii	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Баян-Овоо сумаас уршлага судлах юмсан.	Сайн байна уу? Энэ нэвтрүүлгийг үзээрэй! https://www.youtube.com/watch?v=3n4A9-dHsQk...
1 8	Olzii Ochir	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	сайн бн уу? танай онхсангаар манай хороонд хийгдсэн ажлын чанар гүйцэтгэл, зураг, төсвийн талаар хаанаас мэдээлэл авч болох вэ?	Сайн байна уу? Та хорооныхоо Засаг даргаас мэдээлэл авч болно. Зураг, төсөв гэх мэт дэлгэрэнгүй мэдээлэл авах бол дүүргийнхээ ОНХС-ийн хариуцсан мэргэжилтнээс асуугаарай. Мөн Дүүргийн цахим хуудсанд өнгөрсөн онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтуудын мэдээлэл байвал түүнээс авч болно. "Тогтвортой амьжиргаа-3" төслийн хүрээнд 330 сумыг ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд мэдээллээ шивсэн эсэхэд үнэлгээ хийдэг тул сумдын хувьд ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд энэ тоонууд шивэгдсэн байдаг. http://tusuv-oronnutag.mof.gov.mn/ ОНХС-ийн цахим хуудасны "Мэдээллийн сан" хэсэгт орж үзэх боломжтой.
1 9	Myagmarsuren Megzem	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч буйд талархаж байна.	
2 0	Galbadrakh Gombojav	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	иргэд та бүхэн myselenge.com хаягаар орж 2020 онд ОНХС-ийн хөрөнгөөр ямар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах саналтай байгаагаа өгөөрэй санал авах хугацаа 5 сард дуусна шүү...	
2 1	Undral Gombodorj	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Ийм ерөнхий мэдэгдлүүд битгий тавь л даа. Тодорхой, баримттай ярь л даа. Ямар төслүүд ирсэн, ХБ-ын ямар чиглэлтэй нь яулдаж байгааг дэлгэрэнгүй бич л дээ.	Сайн байна уу? Иргэдэд мэдээлэл түгээх, иргэдээс санал авах үүрэг нь баг, хорооны Засаг дарга, сумын ОНХС-ийн ажлын хэсэг гэх мэт тус тусын албан хаагчдын үүрэг байдаг. Баг бүр дээр, хороо бүр дээр гаргасан саналууд өөр бөгөөд энэ тухай мэдээллийг баг, хорооны Засаг даргад хандан авах боломжтой. Өнгөрсөн онд батлагдаад энэ онд хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтуудыг дүүрэг, сумынхаа батлагдсан төсвөөс харах боломжтой юм шүү. Улсын хэмжээнд 1500 гаруй багаас олон санал гарч тэр нь сум, дүүрэгт очиж эрэмбэлэгдээд сум, дүүргийнхээ ИТХ-аар батлагддаг учир шат, шатны

				удирдлагуудаасаа мэдээлэл авах, шаардах эрхтэй юм. 5-р сард болдог баг, хорооны ИНХ-ынхаа товыг асууж байгаад хуралдаа заавал оролцож, өөрийн баг, хороонд хийлгэх хүсэлтэй байгаа хөрөнгө оруулалтуудад саналаа гаргаарай та.
2 2	Khukhuusuren Bodoosh	Пост	БГД-н 17-р хороонд орших 22 - р дунд сургуульд 1-5-р ангийн хүүхдүүд сурдаг ба орчин нь маш муу, өвөл битүү мөс хавар намар нь битүү шавар шавхаа, гайгүй гэсэн газар нь машины зогсоол болчихсон бн. Үүнийг шийдэж бага насны хүүхдүүдийг хичээл сургуульдаа явахад нь зориулж тохижуулмаар бн. Мөн Модны 2-н хороолол өгсдөг явган хүний зам бас л дүүрэн машины зогсоол болсон. Үүнийг зохицуулж явган хүний зам, машины зогсоол 2-г ялгаж салгаж өгөөч. Тэр замаар өдөржин ихэнхдээ сургууль цэцэрлэгийн хүүхдүүд бнга дээш доошоо явдаг шүү	
2 3	Гарьд Болортунгалаг	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Yaj oroltsoh ve?	Сайн байна уу? Та баг, хорооныхоо Засаг дарга, хэсгийн ахлагчид ОНХС-ийн санал өгье гээд хандаарай! Мөн санал хураах Иргэдийн нийтийн хуралдаа суумаар байна. Хэзээ болох вэ? ОНХС-ийн талаарх мэдээлэл авмаар байна, тайлбарлаж өгөөч гээд хандаарай! Ер нь иргэд 5-р сард хийгдэх ИНХ-аас өмнө саналын хуудсаар саналаа өгөөд 5-р сард хийгдэх ИНХ дээрээ очиж саналаа баталгаажуулах хэрэгтэй байдаг. Та www.tusuv-oronnutag.mof.gov.mn сайтаар орж мөн мэдээлэл авч байгаарай!

2 4	Munhbold Baatar	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Модуль 1, 2-ын сургалтад аймгийн ЗДТГ-аас яагаад оролцуулаагүй вэ	Сайн байна уу? "Тогтвортой амьжиргаа-3" төсөл нь сумдын ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах зорилготой хэрэгждэг тул зорилтот бүлэг нь сумдын албан хаагч нар байдаг. Гэхдээ аймаг дээр "Аймаг дахь чадавх бэхжүүлэх баг" ЗДТГ-т байдаг, мөн "Тогтвортой амьжиргаа-3" төслийн ажилтан байдаг. Эдгээр хүмүүстэй холбогдоод мэдээлэл авч байгаарай.
2 5	Ганчимэг Чүлтэмсүрэн	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	ЖГҮнэлгээний дүн ямар сайхан мэдээ вэ	
2 6	Gal Gal Candy	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Амжилт хүсье ээ	Баярлалаа. Бусад хүмүүс мэдээлэл авахад туслаад мэдээллийг түгээж байгаарай. Амжилт хүсье.
2 7	Battsetseg Goitiiz	ОНХС-ийн фэйсбүүк хуудсанд сэтгэгдлээр	Дажгүй сайхан болсон байна. Төлөвлөсөнөө ажил болгосонд баяр хүргэе!	Баярлалаа. Манай хуудсанд найзуудаа урьж бусдад мэдлэг түгээхэд тус дэм болохыг хүсье.